



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 04-ны өдөр

№ 25/05

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн А/06 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн толгой компани болох “Эс Ай Би Жэй Капитал” ГХОХХК-тай тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Зээлийн гэрээ болон Барьцааны гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ч. ХАШЧУЛУУН

Д. ЭНХБАТ

Ч. ӨНӨРЖАРГАЛ

Т. ТЭЛМЭН